



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2023 он

Миндуг Аудит ХХК  
Гүйцэтгэх захирал С.Энхтөр  
Утас: 95957791  
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо  
Утас: 90098901  
Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	144
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	154
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	155
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	1515
4.5.1 Завсрын аудитын талаар.....	155
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	166
5.1 Албан шаардлага.....	<b>Error! Bookmark not defined.</b> 6
5.2 Зөвлөмж .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

#### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.25 № 109

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН УУЛБАЯН  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
З.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна. Тайланд онд 1,141,396.9 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,104,949.0 мянган төгрөг зарцуулж 96.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

### Аудитын гол асуудал

Улсын төсвөөс 945,361.6 мянга, орон нутгийн төсвөөс 143,413.0 мянга, нэмэлт санхүүжилтээр 8,005.2 мянга, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид 1,380.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,625.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,040,202.5 мянган төгрөг зарцуулсныг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл

D:/Bichig hereg/2023/A4 toot

ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>61,537,591.63</b>	<b>96,688,067.20</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	29,293,624.57
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	29,293,624.57
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	29,293,624.57
31211	Төрийн сангийн харилцах	-	29,293,624.57
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>507,885.00</b>	<b>507,885.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	507,885.00	507,885.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	507,885.00	507,885.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>61,029,706.63</b>	<b>66,886,557.63</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>6,816,884.00</b>	<b>6,816,884.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	6,476,884.00	6,476,884.00
35130	Эм боох материал	340,000.00	340,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>52,963,822.63</b>	<b>58,820,673.63</b>
35410	Бичиг хэргийн материал	4,427,177.63	4,622,177.63
35420	Аж ахуйн материал	45,467,760.20	45,467,760.20
35440	Түлш, шатах тослох материал	920,710.80	920,710.80
35460	Хүнсний материал	2,148,174.00	7,810,025.00
35600	Мал амьтад	1,249,000.00	1,249,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,623,087,122.93</b>	<b>2,477,347,055.81</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,623,087,122.93</b>	<b>2,477,347,055.81</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,597,086,012.93</b>	<b>2,450,179,279.17</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,528,907,343.29	2,428,907,343.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(122,176,800.52)	(162,550,798.84)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,335,000.00	6,335,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,920,416.97)	(4,611,131.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,620,564.17	246,112,745.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(158,437,023.16)	(173,509,927.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	101,589,012.94	107,589,012.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,908,232.29)	(71,941,166.51)
39214	Бусад үндсэн хөрөнгө	133,581,990.00	133,581,990.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(53,670,321.60)	(63,898,685.28)
39217	Ном	4,164,897.07	4,164,897.07
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>26,001,110.00</b>	<b>27,167,776.64</b>
39301	Програм хангамж	500,000.00	2,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(500,000.00)	(833,333.36)
39303	Бусад биет бус хөрөнгө	26,001,110.00	26,001,110.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,684,624,714.56</b>	<b>2,574,035,123.01</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,684,624,714.56</b>	<b>2,574,035,123.01</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,684,624,714.56	2,574,035,123.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	459,900,261.67	459,900,261.67
51101	Өмч: - төрийн	459,900,261.67	459,900,261.67
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>70,126,178.07</b>	<b>959,536,586.52</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(94,659,902.52)	(1,587,989,541.49)
51220	Тайлант үеийн үр дүн	164,786,080.59	2,547,526,128.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,154,598,274.82	1,154,598,274.82
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,684,624,714.56</b>	<b>2,574,035,123.01</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,034,774,328.62</b>	<b>3,665,053,488.56</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>238,050,741.62</b>	<b>2,560,104,519.56</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	238,050,741.62	2,560,104,519.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	238,050,741.62	2,560,104,519.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	238,050,741.62	2,560,104,519.56
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>796,723,587.00</b>	<b>1,104,948,969.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>728,559,700.00</b>	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	728,559,700.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,790,987.00</b>	<b>8,005,169.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,898,782.00	1,380,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,892,205.00	6,625,169.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>57,372,900.00</b>	<b>143,413,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,372,900.00	143,413,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	953,530,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	953,530,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>864,807,648.03</b>	<b>1,117,527,360.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>864,807,648.03</b>	<b>1,117,527,360.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>814,096,365.76</b>	<b>1,091,471,312.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>559,353,937.68</b>	<b>694,740,645.35</b>
210101	Үндсэн цалин	441,146,165.36	506,950,921.06
210102	Нэмэгдэл	85,041,281.64	146,547,108.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,204,464.00	-
210104	Урамшуулал	30,962,026.68	41,242,615.87
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,378,292.72</b>	<b>85,519,761.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,957,097.95	59,334,962.92
210202	Тэтгэмжийн даатгал	4,855,298.91	6,980,746.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,139,132.09	5,564,176.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,177,712.14	1,226,273.17
210205	Эрүүл мэндийн даатгал	9,249,051.63	12,413,601.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>51,960,873.33</b>	<b>54,128,386.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,394,406.00	20,092,996.00
210302	Түлш, халаалт	40,095,822.33	29,353,390.00
210303	Цэвэр, бохир ус	2,470,645.00	4,682,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,282,192.00</b>	<b>21,098,266.00</b>
210401	Бичиг хэрэг	1,103,162.00	47,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,994,800.00	20,496,266.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	992,000.00	-
210404	Ном, хэвлэл	1,670,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	298,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,223,030.00	555,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,490,424.00</b>	<b>105,275,887.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	498,000.00	-
210502	Хоол, хүнс	21,698,224.00	105,275,887.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,294,200.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,629,000.00</b>	<b>12,877,700.00</b>
210604	Урсгал засвар	4,629,000.00	12,877,700.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>493,800.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	493,800.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>260,000.00</b>	<b>8,494,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	260,000.00	2,918,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,576,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>92,247,846.03</b>	<b>109,336,467.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,768,205.00	23,111,619.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,849,000.00	10,492,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,630,641.03	75,732,248.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,711,282.27</b>	<b>26,056,048.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>36,647,880.00</b>	<b>18,606,600.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	975,100.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,672,780.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	18,606,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>14,063,402.27</b>	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,063,402.27	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	7,449,448.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,449,448.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>169,966,680.59</b>	<b>2,547,526,128.01</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	5,180,600.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5,180,600.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(5,180,600.00)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>164,786,080.59</b>	<b>2,547,526,128.01</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>796,723,587.00</b>	<b>1,104,948,969.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>796,723,587.00</b>	<b>1,104,948,969.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	728,559,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	728,559,700.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,790,987.00</b>	<b>8,005,169.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,898,782.00	1,380,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,892,205.00	6,625,169.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>57,372,900.00</b>	<b>143,413,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,372,900.00	143,413,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	<b>953,530,800.00</b>
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	953,530,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>795,023,687.00</b>	<b>1,047,651,963.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>795,023,687.00</b>	<b>1,047,651,963.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>752,575,914.73</b>	<b>959,518,877.43</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>558,903,937.68</b>	<b>694,740,645.35</b>

210101	Үндсэн цалин	440,696,165.36	506,950,921.06
210102	Нэмэгдэл	85,041,281.64	146,547,108.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,204,464.00	-
210104	Урамшуулал	30,962,026.68	41,242,615.87
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,378,292.72</b>	<b>85,519,761.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,957,097.95	59,334,962.92
210202	Тэтгэмжийн даатгал	4,855,298.91	6,980,746.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,139,132.09	5,564,176.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,177,712.14	1,226,273.17
210205	Эрүүл мэндийн даатгал	9,249,051.63	12,413,601.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>51,960,873.33</b>	<b>74,624,652.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,394,406.00	20,092,996.00
210302	Түлш, халаалт	40,095,822.33	51,564,656.00
210303	Цэвэр, бохир ус	2,470,645.00	2,967,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,600,492.00</b>	<b>555,000.00</b>
210401	Бичиг хэрэг	1,103,162.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,994,800.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	992,000.00	-
210404	Ном, хэвлэл	1,703,700.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	298,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,508,030.00	555,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,770,514.00</b>	<b>48,860,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	498,000.00	-
210502	Хоол, хүнс	26,978,314.00	48,860,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,294,200.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>12,877,700.00</b>
210604	Урсгал засвар	5,000,000.00	12,877,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>493,800.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	493,800.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>260,000.00</b>	<b>8,494,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	260,000.00	2,918,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,576,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,208,005.00</b>	<b>33,846,219.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,824,005.00	23,306,619.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,384,000.00	10,539,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,447,772.27</b>	<b>88,133,086.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,384,370.00</b>	<b>80,683,638.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	975,100.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,409,270.00	62,077,038.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	18,606,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>14,063,402.27</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,063,402.27	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>7,449,448.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,449,448.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,699,900.00</b>	<b>57,297,005.57</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,699,900.00</b>	<b>28,003,381.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,699,900.00</b>	<b>28,003,381.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,699,900.00</b>	<b>28,003,381.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,699,900.00	28,003,381.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,699,900.00)	(28,003,381.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	29,293,624.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	29,293,624.57

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	459,900,261.67	1,154,598,274.82	(94,659,902.52)	-	1,519,838,633.97
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	459,900,261.67	1,154,598,274.82	(94,659,902.52)	-	1,519,838,633.97
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	164,786,080.59	-	164,786,080.59
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,900,261.67	1,154,598,274.82	70,126,178.07	-	1,684,624,714.56
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	459,900,261.67	1,154,598,274.82	70,126,178.07	-	1,684,624,714.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,658,115,719.56)	-	(1,658,115,719.56)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	459,900,261.67	1,154,598,274.82	(1,587,989,541.49)	-	26,508,995.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,547,526,128.01	-	2,547,526,128.01
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,900,261.67	1,154,598,274.82	959,536,586.52	-	2,574,035,123.01

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,141,396,900.00	1,075,655,344.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,141,396,900.00	1,075,655,344.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,060,705,200.00	994,971,706.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	722,345,600.00	694,740,645.35
210101	Үндсэн цалин	538,517,200.00	506,950,921.06
210102	Нэмэгдэл	158,216,900.00	146,547,108.42
210104	Урамшуулал	25,611,500.00	41,242,615.87

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>89,855,400.00</b>	<b>85,519,761.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	61,111,100.00	59,334,962.92
210202	Тэтгэмжийн даатгал	7,189,700.00	6,980,746.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,751,500.00	5,564,176.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,436,600.00	1,226,273.17
210205	Эрүүл мэндийн даатгал	14,366,500.00	12,413,601.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>111,944,100.00</b>	<b>82,074,100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,000,000.00	20,092,996.00
210302	Түлш, халаалт	92,992,300.00	59,014,104.00
210303	Цэвэр, бохир ус	2,951,800.00	2,967,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,347,000.00</b>	<b>555,000.00</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,347,000.00	555,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>48,860,700.00</b>	<b>48,860,700.00</b>
210502	Хоол, хүнс	48,860,700.00	48,860,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,877,700.00</b>	<b>12,877,700.00</b>
210604	Урсгал засвар	12,877,700.00	12,527,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,156,400.00</b>	<b>10,074,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,918,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,156,400.00	7,156,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,318,300.00</b>	<b>60,269,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,583,700.00	49,535,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,734,600.00	10,734,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,691,700.00</b>	<b>80,683,638.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>80,691,700.00</b>	<b>80,683,638.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,085,100.00	62,077,038.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,606,600.00	18,606,600.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,141,396,900.00</b>	<b>1,104,948,969.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,141,396,900.00</b>	<b>1,104,948,969.00</b>
122005	Орон нутгийн төсвөөс	1,141,396,900.00	1,104,948,969.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>29,293,624.57</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Сангийн яамны 2023 оын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал “Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-ын удирдамжийн дагуу холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388, 32-дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөж

нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”, “Сангийн сайдын 2008 оны Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 252 дугаар тушаалыг баримтлал болгон бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 889,410.4 мянган төгрөгөөр буюу 34.5 хувиар өссөн байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	29,293.6	29,293.6
Авлага	507.9	507.9	0
Бараа материал	61,029.7	66,886.6	5,856.9
Үндсэн хөрөнгө	1,623,087.1	2,477,347.1	854,259.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,684,624.7</b>	<b>2,574,035.1</b>	<b>889,410.4</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	<b>1,684,624.7</b>	<b>2,574,035.1</b>	<b>889,410.4</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,684,624.7</b>	<b>2,574,035.1</b>	<b>889,410.4</b>

Нийт орлого 2,630,279.2 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн өмчийн өөрчлөлтийн тайлан дээр үндэслэн үндсэн хөрөнгө, бараа материалын эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дээр нэмэгдүүлсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,477,347.1 мянган төгрөг болж, 854,259.9 мянган төгрөгөөр буюу 34.0 хувиар, бараа материалын үлдэгдэл 66,886.6 мянган төгрөг болж 5,856.9 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 252,719.7 мянган төгрөг буюу 22.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, нэмэгдэл, хоол хүнсний зардал байна. Цалингийн зардал 135,386.7, гэрэл цахилгааны зардал 10,698.6, хоол хүнсний зардал 83,577.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,174,556.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 33,160.1 мянган төгрөгөөр бууруулж, 1,141,396.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 14 зорилтыг арга хэмжээг санхүүжүүлэхэд 1,141,396.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 953,530.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 143,413.0 мянган төгрөг, өөрсдийн үйл ажиллагааны орлогоор 8,005.2 мянган төгрөгийн санхүүжилт хийгджээ.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	81806-Дотуур байрны үйлчилгээ	65,347.6	63,553.1	1,794.5	97,5%
2	81834-Боловсроын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	661,992.3	636,228.1	25,764.2	96,1%
3	80312-Сургалт семинар	1,431.3	1,431.3	0.05	100%
4	81801-Үдийн цай	62,085.1	62,077.0	8.1	99,9%
5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	16,485	16,484.4	0.6	100%
6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	133,594.3	133,248.2	346.1	99,7%
7	83602-ЗГ болон засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан	-	-	1,380.0	0
8	80111-Төрийн өмчит өмчийн тогтмол зардал	124,821.8	94,951.8	29,870	100%
9	80112-Нийтлэг үйлчилгээ	52,497.3	48,461.2	4,036.1	100%
10	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	2,862.6	2,862.6	-	100%
11	81605-Эрүүл мэндийг дэмжих	3,291.9	3,291.9	-	100%
12	81823-Боловсролын байгууллагын багш ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх	6,440.7	6,440.7	-	100%
13	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	4,752.6	3,706.9	1,045.7	100%
14	81848-Сурах бичгийн түрээс	5,794.4	2,918.2	2,876.2	100%
<b>НИЙТ</b>		<b>1,141,396.9</b>	<b>1,075,655.3</b>	<b>67,121.5</b>	<b>97%</b>

Тогтмол зардал, нийтлэг үйлчилгээ, гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах, сурах бичгийн түрээсийн үйлчилгээ 37,828.0 мянган төгрөгөөр дутуу олгогдож төсөв хэмнэгдсэн харагдаж байна. Улсын төсвийн санхүүжилтийн мөнгөн гүйлгээний эцсийн үлдэгдэл 29,293.6 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн МНБ,ТМЗ, аудитор С.Энхтөр, аудиторын туслах Ш.Ундрах нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 8,648.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,053.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд түлш, халаалтын зардал 10,742.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн бол гэрэл, цахилгааны зардал 10,698.6, хоол хүнсний зардал 83,577.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

---

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томиллолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Гэрэл, цахилгааны зардал: Дотуур байр шинээр ашиглалтад орж, халаалт цахилгаанаар шийдэгдсэнтэй холбоотойгоор 53.3 хувиар нэмэгдсэн байна.
- Хоол хүнсний зардал өмнөх оноос дунжаар 79.4 хувиар нэмэгдсэн нь дотуур байр ашиглалтад орж, хүүхдийн тоо нэмэгдсэн, мөн 2021 онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж зардал бага гарч байсан бол тайлант онд үйл ажиллагаа хэвийн явагдсанаас зардал өссөн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 32 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуульд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн залруулга, албан шаардлагыг 100% бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,835.2	2	2,835.2	100%
Албан шаардлага	1	5,653.3	1	5,653.3	100%

<b>Зөвлөмж</b>	<b>3</b>	<b>786,022.5</b>	<b>3</b>	<b>786,022.5</b>	<b>100%</b>
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>794,511.0</b>	<b>6</b>	<b>794,511.0</b>	<b>100.0%</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,663.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 17,125.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, байгууллагын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 2 зөвлөмжийг хүргүүлээ.

### 5.1 Албан шаардлага

Нийт 12 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 17,125.9 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалтыг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эзэн холбогдогч нь тодорхойгүй 507,9 мянган төгрөгийн удаан жилийн насжилттай авлага бүртгэгдсэн байна.

#### 1.2 Өгсөн зөвлөмж:

Эзэн холбогдогч нь тодорхойгүй насжилт урттай авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах

#### 2. Шилэн данстай холбоотой асуудал

#### 2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст нийт 146 мэдээллийг хугацаанд нь оруулж ил тод байршуулахаас 32 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан “цаг хугацаанд нь, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалтыг хангахгүй байна.

#### 2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

